

2016 оны...дугаар
сарын....-ны өдөр

Улаанбаатар хот

**СОГТУУРЧ, МАНСУУРЧ ДОНТОХ ӨВЧТЭЙ
ЭТГЭЭДИЙГ ЗАХИРГААНЫ ЖУРМААР АЛБАДАН ЭМЧЛЭХ ТУХАЙ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
Нийтлэг үндэслэл**

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь согтуурч, мансуурч донтох өвчтэй хүнийг албадан эмчлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Согтуурч, мансуурч донтох өвчтэй хүнийг албадан эмчлэх тухай хууль тогтоомж

2.1.Согтуурч, мансуурч донтох өвчтэй хүнийг албадан эмчлэх тухай хууль тогтоомж нь Эрүүл мэндийн тухай хууль¹, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль², Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль³, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль⁴, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Албадан эмчлэх үндэслэл

3.1.Согтуурсан, мансуурсны улмаас өөртөө болон бусдад аюул учруулах эрсдэлтэй байдалд орсон хүн дараахь донтох өвчтэй нь эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон боловч сайн дураар эмчлүүлэхээс татгалзсан бол шүүхийн шийдвэрээр албадан эмчилгээнд хамруулна:

- 3.1.1.согтуурч донтох өвчтэй;
- 3.1.2.мансуурч донтох өвчтэй.

3.2.Энэ хуулийн 3.1-д заасан донтох өвчний оношийг тогтооход эрүүл мэндийн салбарт мөрдөж байгаа оношлогоо, эмчилгээний стандартыг баримтална.

¹ Төрийн мэдээлэл 2011 №21

² Төрийн мэдээлэл 2000 №6

³ Төрийн мэдээлэл 2013 №3

⁴ Төрийн мэдээлэл 2002 №8

4 дүгээр зүйл. Эрүүл мэндийн байгууллагын дүгнэлт гаргуулах

4.1. Байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлага, иргэн санаачлан согтуурч, мансуурч донтох өвчний улмаас өөртөө болон бусдад аюул учруулах эрсдэлтэй байдалд орсон хүнийг албадан эмчлүүлэхээр тухайн хүний оршин суугаа нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад хандаж хүсэлт гаргана.

4.2. Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага тухайн хүний хувийн байдлыг тогтоох баримт бичиг, тодорхойлолт бүрдүүлж, энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан донтох өвчтэй эсэх талаар дүгнэлт гаргуулахаар түүнийг харьяа эрүүл мэндийн байгууллагад хүргэнэ.

4.3. Эрүүл мэндийн байгууллага тухайн хүнийг согтуурч, мансуурч донтох өвчтэй эсэхийг тодорхойлсон дүгнэлтийг үзлэг хийснээс хойш 48 цагийн дотор гаргаж өгнө.

4.4. Эрүүл мэндийн байгууллага дүгнэлт гаргахдаа тухайн хүн согтуурч, мансуурч донтох өвчнийг эмчлэх эмчилгээнд харшлах өвчтэй эсэхийг төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг, шинжилгээ хийж тогтоосон байх шаардлагатай ба харшлах өвчтэй тохиолдолд харшлах өвчин, эмчилгээний эсрэг заалт, хориглох заалт, хүндрэл, гаж нөлөөг дүгнэлтэд зааж, албадан эмчилгээнд явуулахыг хориглох эсэх тухай тодорхой бичнэ.

4.5. Эмч өөрийн мэргэжлийн чиглэлээр худал дүгнэлт гаргасан, эсхүл тухайн хүн согтуурч, мансуурч донтох өвчнийг эмчлэх эмчилгээнд харшлах өвчтэй байхад энэ тухай дүгнэлтэд тодорхойлж бичээгүй тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээнэ.

4.6. Албадан эмчилгээ хийхэд харшлах өвчний жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

4.7. Энэ хуулийн 4.4-т заасан эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтийг тухайн хүн, түүний гэр бүлийн гишүүдийн зүгээс хүлээн зөвшөөрөхгүй нөхцөлд дараагийн шатлалын эмнэлэгт хандан гомдол гаргаж болно.

4.8. Согтуурч, мансуурч донтох өвчтэй тухай эрүүл мэндийн байгууллагын дүгнэлт гарсны дараа тухайн хүн өөрөө сайн дураар эмчлүүлэх хүсэлтээ бичгээр гаргаж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад өгсний дагуу байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлага, иргэний зүгээс уг хүнийг албадан эмчилгээнд явуулах тухай гаргасан хүсэлтээ буцааж авсан нөхцөлд албадан эмчилгээнд явуулахгүй.

5 дугаар зүйл. Албадан эмчлэх тухай шүүхийн шийдвэр гаргах, түүнийг биелүүлэх

5.1.Энэ хуулийн 4.1-д заасан цагдаагийн байгууллага нь албадан эмчилгээнд явуулах хүнд холбогдох дор дурдсан материалыг бүрдүүлж шүүхэд өгнө:

5.1.1.тухайн хүнийг албадан эмчилгээнд явуулах тухай байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлт;

5.1.2.албадан эмчилгээнд явуулах хүний иргэний үнэмлэхний эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийн хуулбар, байхгүй тохиолдолд иргэний бүртгэлийн байгууллагын лавлагааны хуулбар, фото зураг;

5.1.3.оршин суугаа хаягийн тодорхойлолт;

5.1.4.цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

5.1.5.тухайн хүн согтуурч, мансуурч донтох өвчтэй тухай эмнэлгийн дүгнэлт.

5.2.Шүүх энэ хуулийн 5.1-д зааснаас бусад материалыг холбогдох байгууллага, иргэдээс шаардан авч болно.

5.3.Тухайн хүнийг албадан эмчилгээнд явуулах эсэхийг шүүх хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ.Шүүх хуралдааныг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу явуулж, шүүхийн шийдвэр гаргана.

5.4.Шүүх хуралд албадан эмчилгээ хийлгэх хүнийг өөрийг нь болон түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, хүсэлт гаргасан гэр бүлийн гишүүн эсхүл хүсэлт гаргасан байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөл, тухайн хүний оршин суугаа нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын төлөөлөл, шүүхээс шаардлагатай гэж үзсэн бусад хүнийг оролцуулж болно.

5.5.Тухайн хүн, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч нь шүүхийн шийдвэрийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хугацааны дотор давж заалдах гомдол гаргах эрхтэй.

5.6.Шүүхийн шийдвэрийг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн биелүүлнэ.

5.7.Албадан эмчлэх тухай шүүхийн шийдвэр гарах хүртэл хугацаанд тухайн хүнийг саатуулах, шүүхийн шийдвэр гарсны дараа албадан эмчлэх эмнэлэгт хүргэх ажиллагааг цагдаагийн байгууллага гүйцэтгэнэ.

6 дугаар зүйл.Албадан эмчлэх эмнэлэгт хүлээн авах

6.1.Албадан эмчлэх эмнэлэг тухайн хүнийг хүлээж авахдаа дор дурдсан баримт бичгийг шаардана:

6.1.1.шүүхийн шийдвэр;

6.1.2.харьяа эрүүл мэндийн байгууллагын дүгнэлт;

6.1.3.иргэний үнэмлэх, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг, байхгүй тохиолдолд иргэний бүртгэлийн байгууллагын лавлагаа, фото зураг.

6.2.Эмчлүүлэх хүний биед болон эд зүйлд ижил хүйсийн харуул хамгаалалтын ажилтан үзлэг хийж, тус газрын дотоод журамд заасан биедээ авч байлгахыг хориглосон баримт бичиг, мөнгө, эд зүйлийг бүртгэн түр хурааж авна.

6.3.Эмчлүүлэх хүнийг хүлээж авмагц эмчийн үзлэг хийн, өвчний түүх нээж, албадан эмчилгээний зорилго, ач холбогдол, эмчлүүлэгчийн зүгээс эмчилгээний явцад баримтлах дэг, албадан эмчлэх эмнэлгийн дотоод журам, эмчлүүлэгчийн эрх, үүргийг танилцуулна.

6.4.Хэвтэн эмчлүүлэх өрөөнд хуваарилахдаа хүйсийн байдлаар нь болон анх удаа ирж байгаа эмчлүүлэгчийг давтан ирж байгаа эмчлүүлэгчээс тусад нь байрлуулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Албадан эмчлэх эмнэлэг

7 дугаар зүйл.Албадан эмчлэх эмнэлэг

7.1.Албадан эмчлэх эмнэлэг нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын харьяалалд байна.

7.2.Албадан эмчлэх мэргэжлийн удирдлагыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, харуул хамгаалалтыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна.

7.3.Албадан эмчлэх эмнэлгийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

7.4.Албадан эмчлэх эмнэлэг нь эмчлүүлэгчид Эрүүл мэндийн тухай хуульд заасны дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлнэ.

7.5.Албадан эмчлэх эмнэлэг нь өөрийн үйл ажиллагааны чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүнтэй хамтран ажиллаж болно.

7.6.Албадан эмчлэх эмнэлгийн хөдөлмөрийн дотоод журмыг эмнэлгийн дарга батална.

8 дугаар зүйл.Эмчлэх мэргэжлийн удирдлага

8.1.Албадан эмчлэх эмнэлгийн мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлэх эрүүл мэндийн байгууллагаас дараахь чиглэлийн үйл ажиллагааг зохион байгуулна:

8.1.1.Албадан эмчлэх эмнэлгийн мэргэжилтнийг мэргэшүүлэх, давтан сургах ажлыг зохион байгуулах, эмнэлгийн мэргэжилтнээр хангах ажилд дэмжлэг туслалцаа үзүүлэх;

8.1.2.эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хяналт тавих;

8.1.3.оношлогоо, эмчилгээний багаж, тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгсэл болон холбогдох бусад техник хэрэгслийн хангамж, тэдгээр нь эрүүл ахуйн болон стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, хяналт тавих;

8.1.4.согтуурч, мансуурч донтох эмгэгтэй эмчлүүлэгчийн эмчилгээний арга барилыг сайжруулах, үр дүнг тооцох, энэ чиглэлээр судалгаа, шинжилгээний ажлыг гүйцэтгүүлэх, цаашид баримтлах бодлогыг тодорхойлох;

8.1.5.албадан эмчлэх эмнэлгийн үйл ажиллагааг бусад эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулах:

8.1.6.дараагийн шатлалын эсхүл төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээ шаардлагатай эмчлүүлэгчийг зориулалтын унаагаар тээвэрлэн хүргэх түргэн тусламжийн үйлчилгээнд хамруулах;

8.1.7.хуульд заасан бусад ажиллагаа.

8.3.Согтуурч донтох өвчтэй хүнийг албадан эмчлэх журам, Мансуурч донтох эмгэгтэй хүнийг албадан эмчлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8.4.Согтуурч, мансуурч донтох өвчтэй хүнийг албадан эмчлэх эмнэлгийн байр болон эмнэлгийн үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага, стандартыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Стандартчилал тохирлын үнэлгээний тухай хуульд заасны дагуу батлуулна.

9 дүгээр зүйл.Албадан эмчлэх эмнэлгийн хамгаалалт

9.1.Албадан эмчлэх эмнэлгийн аюулгүй байдал, харуул хамгаалалтыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна.

9.2.Албадан эмчлэх эмнэлгийн харуул хамгаалалтын журмыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга Улсын ерөнхий прокурортой хамтран батална.

9.3.Албадан эмчлэх эмнэлгээс эмчлүүлэгч оргосон тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хариуцан шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллага хамтран эрэн сурвалжилж, эмнэлэгт буцаан хүргэнэ.

10 дугаар зүйл.Албадан эмчлэх эмнэлгийн санхүүжилт

10.1.Албадан эмчлэх эмнэлгийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

10.2.Албадан эмчлэх эмнэлгийн зардалд энэ хуулийн 3.1-д заасан өвчнөөс гадна тухайн хүнд илэрсэн бусад өвчнийг эмчлэх, нөхөн сэргээх тусламж үйлчилгээ үзүүлэх, эмнэлгийн хувцас, өвчний байдлаас шалтгаалж өгөх эмчилгээний хоолны болон албадан эмчлэх эмчилгээ дууссаны дараа буцах зэрэг зардлыг тус тус оруулж тооцно.

10.3.Албадан эмчлэх эмнэлгийн санхүүжилтэд Засгийн газрын тусгай сан болон аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, иргэний хандив, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр байж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Албадан эмчлэх

11 дүгээр зүйл.Албадан эмчилгээ хийх

11.1.Албадан эмчилгээг тухайн өвчний үед баримталдаг эмчилгээний аргачлал, стандартын дагуу явуулах ба дараахь зарчмыг баримтална.

11.1.1.хүний эрхийг хүндэтгэн харьцах;

11.1.2.зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт болон улсын бүртгэлд бүртгэгдсэн эм, бэлдмэлийг хэрэглэх;

11.1.3.эмчлүүлэгчийн нууцыг хадгалах.

11.2.Согтуурч, мансуурч донтох өвчтэй хүн эмчлүүлэхээс зайлсхийх, дур мэдэн явах боломжгүй байнгын харуул хамгаалалт бүхий эмнэлэгт албадан эмчилгээг явуулна.

11.3.Албадан эмчлэх эмнэлэг эмчлүүлэгчид зайлшгүй шаардлагатай шинжилгээ, эмчилгээг стандартын дагуу хийж, албадан эмчилгээний явцыг өвчний түүхэнд үнэн зөв, тодорхой бичнэ.

11.4.Эмчлүүлэгч эмчилгээ хийлгэхээс татгалзвал түүнд харуул хамгаалалтын ажилтны хяналтад эмчийн заавраар албадан эмчилгээг хийж, энэ тухай өвчний түүхэнд тэмдэглэнэ.

11.5.Албадан эмчлүүлж байгаа хүнд Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд заасан сэтгэц-нийгмийн сэргээн засах тусламж үйлчилгээг цогц байдлаар үзүүлнэ.

11.6.Албадан эмчлэх эмнэлэг нь эмчлүүлэгчийн донтох өвчнийг эмчлэхийн зэрэгцээ тухайн хүний биед илэрсэн дагалдах бусад өвчнийг эмчлэх ба тус эмнэлэгт эмчлэх боломжгүй нөхцөлд эмчлүүлэгчийг төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэгт шилжүүлнэ.

12 дугаар зүйл.Эмчлүүлэгчийн эрх, үүрэг

12.1.Эмчлүүлэгч дараахь эрхтэй:

- 12.1.1.албадан эмчлэх эмнэлгийн дотоод журамтай танилцах;
- 12.1.2.эмнэлгийн шаардлагатай эмчилгээ үйлчилгээ авах болон зохих эрүүл ахуйн шаардлага хангасан ахуй нөхцөл, эмчилгээний дэглэмд зохицсон хоол хүнсээр хангуулах;
- 12.1.3.Эмнэлгийн дотоод журамд хориглоогүй хувцас, хэрэглээний эд зүйл, хүнсний бүтээгдэхүүн хэрэглэх;
- 12.1.4.гэр бүлийн хүмүүстэйгээ чөлөөтэй уулзах, эргэлт авах, захиа бичих, утсаар ярих;
- 12.1.5.хувийн аюулгүй байдлаа хамгаалуулах;
- 12.1.6.эмнэлгийн үйл ажиллагаа, эмчилгээ, шинжилгээний талаар санал өгөх, гомдол гаргах;
- 12.1.7.ар гэрт нь гачигдал, зовлон учирсан болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар тус эмнэлгийн дотоод журамд заасны дагуу чөлөө авах.

12.2.Эмчлүүлэгч дараахь үүрэгтэй:

- 12.2.1.Албадан эмчлэх эмнэлэгт тогтоосон дүрэм, журмыг мөрдөх;
- 12.2.2.албан хаагчдын хууль ёсны шаардлагыг биелүүлэх;
- 12.2.3.стандартын дагуу шаардлагатай эмчилгээ хийлгэх;

13 дугаар зүйл.Тусгаарлах өрөө

13.1.Эмчлүүлэгч согтуурч, мансуурсны улмаас догшин авирлаж, бусдад аюултай үйлдэл хийж болзошгүй байдал үүсгэсэн тохиолдолд тусгаарлах өрөөнд оруулна.

13.2.Тусгаарлах өрөөнд байгаа эмчлүүлэгчийн эрүүл мэндэд эмч хяналт тавьж, хийсэн эмчилгээний талаар эмчлүүлэгчийн өвчний түүхэнд тэмдэглэнэ.

13.3.Тусгаарлах өрөөнд эмчлүүлэгчийг 24 цагаас дээш хугацаагаар байлгахыг хориглох ба шаардлагатай тохиолдолд эмчийн дүгнэлтээр хугацааг сунгаж болно.

13.4.Тусгаарлах өрөөнд тавигдах шаардлага, хяналт тавих зааврыг энэ хуулийн 9.2-т заасан журамд тусгана.

14 дүгээр зүйл.Албадан эмчлэх хугацаа

14.1.Албадан эмчилгээг 3 сараас доошгүй хугацаанд хийх ба эмчлүүлэгчийн биеийн байдал, эмчилгээний үр дүнгээс шалтгаалан эмчлэх хугацааны дээд хязгаарыг Албадан эмчлэх эмнэлэг тодорхойлно.

14.2.Албадан эмчлэх эмнэлгээс эмчлүүлэгч оргож, эмнэлэгт буцаан хүргэгдэж ирсэн тохиолдолд эмчилгээний хугацааг нөхөн сунгана.

15 дугаар зүйл.Албадан эмчлэх хугацаа дуусах

15.1.Албадан эмчилгээний үр дүнг харгалзан эмчилгээг дуусгавар болгох тухай саналыг Албадан эмчлэх эмнэлэг шүүхэд гаргана.

15.2.Албадан эмчлэх эмнэлгийн саналыг шүүх хуралдаанаар хэлэлцэнэ. Албадан эмчилгээний хугацаа нь Шүүхийн шийдвэрээр дуусгавар болно.

15.3.Албадан эмчлэх эмнэлэг нь эмчилгээнд харшлах өвчин илэрсэн тохиолдолд эмчлүүлэгчийн эмчилгээг хугацаанаас нь өмнө зогсоох тухай хүсэлтийг шүүхэд гаргаж болно.

15.4.Албадан эмчлэх эмнэлэг нь эмчлүүлэгчийн эмчилгээ дууссан тухай мэдээллийг эмчлүүлэгчийн харьяалах нутаг дэвсгэрт орших эмнэлгийн сэтгэц, наркологийн эмч, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад шүүхийн шийдвэр гарснаас хойш долоо хоногийн дотор хүргүүлнэ.

15.5.Шүүхийн шийдвэрийн дагуу албадан эмчилгээний хугацаа дуусч эмнэлгээс гарч байгаа хүнд түр хураан авсан баримт бичиг, мөнгө, эд зүйлийг бүртгэлийн дагуу буцааж өгнө.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ Бусад зүйл

16 дугаар зүйл.Нийгмийн халамжид хамруулах

16.1.Албадан эмчлэх эмнэлэг нь эмчлүүлж байгаа хүн хууль ёсны асран хамгаалах, харгалзан дэмжих хүнгүй, гэр оронгүй, ажил эрхэлдэггүй бол энэ тухай мэдээллийг түүний оршин суугаа газрынх нь нийгмийн халамж, үйлчилгээний асуудал хариуцсан байгууллагад тухайн хүнийг эмнэлэгт хүлээн авснаас хойш долоо хоногийн дотор хүргүүлнэ.

16.2.Албадан эмчлэх эмнэлгийн мэдээллийн дагуу нийгмийн халамж, үйлчилгээний асуудал хариуцсан байгууллага нь тухайн хүмүүсийг судалж, эмнэлгээс гарахад нь иргэний улсын бүртгэлд бүртгүүлэх, ажилд зуучлах, нийгмийн халамжид хамруулах арга хэмжээ авна.

17 дугаар зүйл.Албадан эмчлүүлсний дараа авах арга хэмжээ

17.1.Албадан эмчлэх газарт эмчлүүлсэн хүн эмчилгээ дууссаны дараа оршин суугаа нутаг дэвсгэрт байрлах эмнэлгийн сэтгэц, наркологийн эмчид бүртгүүлэн эмчилгээний заавар, стандартын дагуу бататгах эмчилгээнд хамрагдана.

17.2.Сэтгэц наркологийн эмч болон тухайн засаг захиргааны нэгжийн нийгмийн ажилтан бататгах эмчилгээнд хамрагдаж байгаа хүнд зориулан нийгэм,

хамт олонд түшиглэсэн сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тухайн чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран явуулж болно.

18 дугаар зүйл.Гомдол гаргах

18.1.Албадан эмчлүүлж байгаа хүн, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч албадан эмчлэхтэй холбогдсон гомдлыг шүүхэд гаргаж болно.

19 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

19.1.Энэ хуулийг 201. оны .. дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.